МЭДЭЭ · 2022 оны 10-р сарын 3

АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ ХИЙЛЭЭ



Монгол Улсын Их Хурлаас баталсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд Авлигатай тэмцэх газраас Баянхонгор аймагт зохион байгуулсан сургалтад тус аймгийн прокурорын газраас оролцож, орон нутаг дахь авлигын гэмт хэргийн нөхцөл байдлын талаар мэдээлэл хийлээ.

Энэхүү сургалтад аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд, орон нутгийн өмчийн аж ахуй нэгж, төсөвт байгууллагуудын төлөөлөл оролцсон байна.

Баянхонгор аймагт Авлигын гэмт хэрэг 2021 онд 8,1 хувиар, 2022 оны 9 сарын байдлаар 20,5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байгаа ажээ.





Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1954